

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2015 ОНЫ АРВАН ДОЛДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2015 оны тавдугаар сарын 07-ны 14 цаг 04 минутад эхэлж, 15 цаг 50 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 1 цаг 46 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Зам тээврийн яамны Төрийн захиргааны удирдлага, хууль эрх зүйн газрын даргын албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай	Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн: Доржсүрэнгийн Занданбатыг Зам тээврийн яамны Төрийн захиргааны удирдлага, хууль эрх зүйн газрын даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Зам тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Бат-Эрдэнэд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
2	Хүнс, хөдөө аж ахуйн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай	Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:

		<p>Одонмажигийн Амгаланбаатарыг Хүнс, хөдөө аж ахуйн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Хүнс, хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Ариунболдод санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
3	<p>Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх төрийн албаны мэргэшлийн шалгалтын дүнгийн тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2015 оны 04 дүгээр сарын 28-29-ний өдрүүдэд Нийслэлд зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Нийслэлд 2015 оны 04 дүгээр сарын 28-29-ний өдрүүдэд зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 1 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 91 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэх.</p> <p>2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 21 иргэнийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар нэр дэвшүүлэх.</p> <p>3. Энэхүү тогтоолын 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 21 нэр дэвшүүлсэн иргэнийг “Нийтийн албанд</p>

		<p>нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль"-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулах арга хэмжээ авахыг Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөл /Ё.Гэрэлчулуун/-д үүрэг болгох</p> <p>4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
4	<p>Төрийн албаны зөвлөлийн Өвөрхангай аймаг дахь Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргыг томилох тухай</p>	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн "Гурав"-ын 3.3, Өвөрхангай аймаг дахь Салбар зөвлөлийн даргын 2015 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 56 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлт, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны зөвлөлийн Өвөрхангай аймаг дахь Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргаар тус аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын газрын Хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн Элбэгийн Бадамгэрэлийг 2015 оны 05 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн томилох.</p> <p>2. Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 141 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын "Хоёр"-ын 13-т "...хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Чимэдцэрэнгийн Бат-Өлзий" гэснийг "Хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн Элбэгийн Бадамгэрэл" гэж өөрчлөх</p> <p>3. "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-д</p>

		<p>заасан чиг үүргийг хууль тогтоомжийн хүрээнд бүрэн хэрэгжүүлж ажиллахыг Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга Э.Бадамгэрэлд үүрэг болгох тухай Монгол Улсын төрийн албаны зөвлөлийн тогтоол гархаар тогтов.</p>
5	<p>Бусад асуудал /Улсын бүртгэлийн Ерөнхий газарт Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянан шалгасан Ажлын хэсгийн дүнгийн тухай/</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 39 дүгээр зүйлийн 39.5 дахь заалтуудыг баримтлан Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 05 дугаар 07-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйл, 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2011 оны 62 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журам”-ыг зөрчин, Увс аймгийн Бүртгэлийн хэлтсийн дарга, Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга, Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын даргын албан тушаалын сул орон тоонд тус тус түр орлон гүйцэтгэгчийг томилсон “Албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэх тухай” Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2014 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 853 дугаар тушаал, 2014 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 1765 дугаар тушаал, 2015 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 383 дугаар тушаалыг тус тус 2015 оны 05 дугаар сарын 07-ны өдрөөс тус тус хүчингүй болгох.</p> <p>2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан албан тушаалд томилогдох ажилтныг Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын дагуу сонгон шалгаруулж, дүгнэлт гарган нэр дэвшүүлж томилуулах ажлыг 2015</p>

оны 6 дугаар сарын 15-ны өдрийн дотор зохион байгуулахыг Төрийн албаны зөвлөлийн Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөл /Ц.Пүрэвдорж/-д даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.

Төрийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.3, 39 дүгээр зүйлийн 39.6, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1, Монгол Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн 4.4 дэх заалтыг тус тус баримтлан, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:

1. Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Ц.Пүрэвдоржийг Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4, 21 дүгээр зүйл, 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2011 оны 62 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журам”-ыг хэрэгжилтийг тус тус хангалтгүй зохион байгуулсан гэж дүгнэх.

2. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг удаа дараа хангалтгүй зохион байгуулсан Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Ц.Пүрэвдоржид холбогдох хууль тогтоомжийн дагуу сахилгын хариуцлага тооцуулах саналыг Засгийн газарт хүргүүлэх.

3. Улсын бүртгэлийн ерөнхий газарт Төрийн албаны тухай хууль тогтоомж, стандартыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд илэрсэн зөрчлийг арилгуулах талаар арга зүйн зөвлөмж хүргүүлэн, хяналт тавьж ажиллахыг Ажлын албаны дарга С.Цэдэндамбад үүрэг болгох.

4. Төрийн албаны зөвлөлийн

		<p>шийдвэр болон зөвлөмжийн дүнг төрийн албаны зөвлөлийн 2015 оны 06 дугаарын 18-ны өдрийн танилцуулахыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөл / Ц.Пүрэвдорж/-д үүрэг болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
--	--	--